



143

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,  
ГЕОДЕЗИ ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 05 сарын 26 өдөр

Дугаар A/131

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.21, 23.2.22 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Газрын мониторингийн системийг ажиллуулах журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү журмыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллахыг тус газрын холбогдох нэгжүүд, аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын алба, сумын Газрын даамлуудад тус тус үүрэг болгосугай.
3. Газрын мониторингийн системийн мэдээллийн баяжилт, мэдээллийн санг эрхэлж, холбогдох албан тушаалтан болон мэргэжлийн байгууллагыг мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллахыг Суурь судалгаа, мониторингийн хэлтэс /П.Нямдаваа/-т, системийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллахыг Орон зайн мэдээлэл, технологийн хэлтэс /Э.Баярмаа/-т тус тус үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлага, хамтын ажиллагааны газар /Р.Ганхуяг/-т даалгасугай.

ДАРГА

Ц.ГАНХҮҮ



08 200449

Газар зохион байгуулалт, геодези,  
зураг зүйн газрын даргын 2020 оны  
*A/131* тоот тушаалын хавсралт

## ГАЗРЫН МОНИТОРИНГИЙН СИСТЕМИЙГ АЖИЛЛУУЛАХ ЖУРАМ



### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны мониторингийн систем /цаашид “Газрын мониторингийн систем” гэх/-ийн үйл ажиллагаа, түүнд шаардлагатай мэдээллийг бүрдүүлэх, боловсруулах, дүн шинжилгээ хийх, мэдээллийг хадгалах, хамгаалах, ашиглуулах, түгээхтэй холбогдсон үйл ажиллагааг зохицуулах, хэрэглэгчид болон иргэд, олон нийтийг нэг эх үүсвэрээс үнэн зөв мэдээллээр хангахад оршино.


1.2. Газрын мониторингийн мэдээллийн санг Газрын мониторингийн системийн үйл ажиллагаагаар эрхэлнэ.

1.3. Газрын мониторингийн системийн үйл ажиллагаанд Газрын тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль, Геодези, зураг зүйн тухай хууль, Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Архивын тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх журам, Байгууллагад мэдээллийн технологийг ашиглах дотоод журам болон энэхүү журмыг дагаж мөрдөнө.

1.4. Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага (цаашид “Агентлаг” гэх), аймаг, нийслэл, дүүргийн Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага (“цаашид аймаг, нийслэл, дүүргийн Газрын алба” гэх), сумын Газрын даамал, мэргэжлийн байгууллагууд, газрын төлөв байдал, чанартай холбоотой үйл ажиллагаа явуулдаг төрийн захиргааны бусад байгууллага энэхүү журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана.

1.5. Энэхүү журам нь газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа, мониторингийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд, эрдэм шинжилгээний байгууллага, төрийн ба төрийн бус байгууллага, иргэд нөгөө талаас газрын мониторингийн мэдээллийн сантай холбоотой аливаа харилцааг зохицуулна.

1.6. Газрын мониторингийн системийн хэвийн үйл ажиллагаа, хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хангахад “Байгууллагад мэдээллийн технологийг ашиглах дотоод журам”-ыг мөрдөнө.



## Хоёр. Нэр томьёоны тайлбар

2.1. Энэхүү журамд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно.

2.1.1. "Газрын мониторинг" гэж экологийн мониторингийн бүрэлдэхүүн хэсэг бөгөөд өгөгдсөн хөтөлбөрийн дагуу газрын нэгдмэл сангийн зориулалт бүрээс сонгогдсон ажиглалтын талбаруудад судалгаа явуулж, газрын төлөв байдал, чанарын өөрчлөлтийг тогтоох, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, таслан зогсоох цогц үйл ажиллагааг ойлгоно;

2.1.2. "Газрын мониторингийн мэдээллийн сан" гэж Монгол улсын газрын нэгдмэл сан тус бүрт сонгогдсон ажиглалтын талбаруудын хөрс, ургамлан нөмрөгийн суурь мэдээлэл, хянан баталгаа, мониторингийн мэдээлэл, газрын төлөв байдал, чанар түүний өөрчлөлтийн мэдээллүүдийг нэгтгэсэн санг ойлгоно;

2.1.3. "Газрын мониторингийн систем" гэж газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа, мониторингийн бүхий л үйл ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулах програм хангамж бүхий цахим системийг ойлгоно;

2.1.4. "Газрын хянан баталгаа" гэж Газрын тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.1 дэх заалтад заасны дагуу ойлгоно;

2.1.5. "Мэргэжлийн байгууллага" гэж газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажил хийх мэргэжлийн байгууллагын эрхийг холбогдох төрийн захиргааны байгууллагаас авсан хуулийн этгээдийг ойлгоно;


2.1.6. "Үндсэн хэрэглэгч буюу мэдээллийн сангийн түгээгч" гэж агентлагын даргын тушаалаар газрын мониторингийн системд нэвтрэх эрх авсан агентлаг, аймаг, нийслэл, дүүргийн Газрын албаны холбогдох албан хаагч, сумын газрын даамлыг ойлгоно;

2.1.7. "Тусгай эрхтэй хэрэглэгч" гэж агентлагийн даргын тушаалаар газрын мониторингийн системд нэвтрэх эрх авсан үндсэн хэрэглэгчээс бусад төрийн байгууллага, хянан баталгаа хийх мэргэжлийн байгууллага, хөрсний лаборатори, тэдгээрийг төлөөлөх албан тушаалтныг ойлгоно;

2.1.8. "Бусад хэрэглэгч" гэж мэдээллийн сангийн өгөгдөл, мэдээллээр хангагдах, лавлагаа авах иргэд, хуулийн этгээдийг ойлгоно;

2.1.9. "Мэдээллийн сангийн нийлүүлэгч" гэж мэдээллийн санд шаардлагатай мэдээллээр газрын мониторингийн системийг хангах мэргэжлийн байгууллага, бусад холбогдох төрийн болон төрийн бус байгууллагыг ойлгоно.

**Гурав. Газрын мониторингийн системийн бүтэц, зохион байгуулалт**



3.1. Газрын мониторингийн систем нь Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн системийн бүрэлдэхүүн хэсэг, газрын мониторингийн мэдээллийн сан нь байгууллагын орон зайн өгөгдлийн дэд бүтцийн мэдээллийн сангийн дэд сан байна.

3.2. Газрын мониторингийн систем нь удирдлагын болон хэрэглэгчийн дэд системээс бүрдэнэ.

3.3. Газрын мониторингийн мэдээллийн систем нь байгууллагын нэгдсэн удирдлагын серверт байршиж, үндсэн сүлжээнд холбогдсон байна.

3.4. Газрын мониторингийн мэдээллийн санг серверт суулгах, тохируулах, сүлжээний холболт, тохиргоо хийх асуудлыг агентлагийн мэдээллийн технологийн асуудал хариуцсан нэгж хариуцна.

3.5. Аймаг, нийслэл, сум, дүүргийн газрын мониторингийн мэдээллийн сангийн бүх өгөгдэл, мэдээлэл, тэдгээрийн шинэчлэлт, өөрчлөлтүүдийг тухай бүрд нь агентлагийн үндсэн сервер, хадгалах төхөөрөмжид хадгалж, улсын хэмжээний нэгдсэн газрын мониторингийн мэдээллийн санг бүрдүүлнэ.

3.6. Газрын мониторингийн системийн удирдлагын дэд системээр дамжуулан дараах үйл ажиллагааг эрхлэнэ. Үүнд:

3.6.1. Хэрэглэгчийн эрхийн зохицуулалт хийх;

3.6.2. Өмчлөл, эзэмшил, ашиглалтад олгогдсон болон төрийн өмчийн бусад газрын төлөв байдал, чанарын мэдээлэл цуглуулах;

3.6.3. Мэдээнд дүн шинжилгээ, боловсруулалт хийх;

3.6.4. Газрын мониторингийг эрхлэх;

3.6.5. Мэдээлэл түгээх;

3.6.6. Газрын мониторингийн нэгдсэн тайлан, мэдээ гаргах;

3.6.7. Хянан баталгааны ажлыг хянах, дүгнэлт баталгаажуулах.

3.7. Газрын мониторингийн системийн хэрэглэгчийн дэд системээр дамжуулан дараах үйл ажиллагаа хийгдэнэ. Үүнд:


3.7.1. Өмчлөл, эзэмшил, ашиглалтад олгогдсон болон төрийн өмчийн бусад газрын төлөв байдал, чанарын мэдээлэл цуглуулах;

3.7.2. Өгөгдэл, мэдээллийн үнэн зөв байдалд хяналт тавих;

3.7.3. Лавлагaa, мэдээллээр иргэд, олон нийтийг хангах үйлчилгээг үзүүлэх;

3.7.4. Мэргэжлийн байгууллага хянан баталгааны ажил гүйцэтгэх;

3.7.5. Хөрсний лаборатори хянан баталгааны ажлын хүрээнд хийгдсэн хөрсний шинжилгээний баталгаажсан хариуг оруулах.



3.8. Үндсэн хэрэглэгчийн холболтын хаяг, сервер компьютерийн нэр нь тогтмол байх ба агентлагийн мэдээллийн технологийн асуудал хариуцсан нэгж хөтөлнө.

3.9. Газрын мониторингийн системийн серверт хандах админ, системийн админы хэрэглэгчийн нэр, нууц үгийг агентлагийн мэдээллийн технологийн асуудал хариуцсан мэргэжилтэн хариуцах ба хувийг битүүмжлэн Архив, мэдээллийн төвийн нууцын эрхлэгчид хадгалуулна.

3.10. Газрын мониторингийн мэдээллийн сан болон тус мэдээллийн сан байрлах серверийн үйлдлийн системд нэвтрэхдээ “SSH” горимоор зохицуулсан нууц түлхүүр ашиглана.

3.11. Газрын мониторингийн систем болон газрын мониторингийн мэдээллийн сангийн хандалтын түүх /log file/-ийг агентлагийн мэдээллийн технологийн асуудал хариуцсан нэгж тухай бүр нууцлан хадгална.

3.12. Агентлагт үндсэн сервер, нөөц сервер, мэдээлэл хадгалах төхөөрөмж байрлана.

3.13. Агентлагийн үндсэн серверт байрлах газрын мониторингийн мэдээллийн сантай мэдээлэл нийлүүлэгчид тоон мэдээлэл дамжуулах байнгын холболт VPN-оор холбогдоно.

3.14. Мэдээлэл нийлүүлэгч байгууллагуудын сүлжээний холболтын хаяг, сервер компьютерын нэр нь тогтмол байх ба системийн админ бүртгэл хөтөлнө.

#### **Дөрөв. Газрын мониторингийн мэдээллийн сан, түүний бүтэц**

4.1. Газрын мониторингийн мэдээллийн сан нь дараах бүтэцтэй байна. Үүнд:

4.1.1. Мониторингийн мэдээллийн сан;

4.1.2. Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны мэдээллийн сан;

4.1.2.1. Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа;

4.1.2.2. Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгаа.

4.2. Газрын мониторингийн мэдээллийн сангийн давхаргуудыг дараах байдлаар ангилна. Үүнд:

4.2.1. Хөдөө аж ахуйн газрын мониторинг;


4.2.2. Хот, тосгон, бусад суурингийн газрын мониторинг;

4.2.3. Ойн сан бүхий газрын мониторинг;

4.2.4. Усны сан бүхий газрын мониторинг;

4.2.5. Улсын тусгай хэрэгцээний газрын мониторинг;

4.2.6. Онцгой нөхцөлийн мониторинг.



4.3. Энэхүү журмын 4.2-т заасан давхаргууд нь засаг захиргааны нэгж бүрээр дахин давтагдашгүй дугаарлалт бүхий ажиглалтын талбаруудаас бүрдэнэ.

4.4. Давхаргын атрибут өгөгдлийг цуглуулж, нэгтгэхдээ агентлагын даргын 2019 оны А/306 дугаар тушаалаар батлагдсан мэдээллийн сангийн загварыг баримтална.

4.5. Газрын мониторингийн мэдээллийн санд дараах баримт бичгүүдийн цаасан эхийг цахим хэлбэрт хөрвүүлж хадгална. Үүнд:

- 4.5.1. Хөрс, ургамлын хээрийн бичиглэл;
- 4.5.2. Лабораторийн шинжилгээний хариу;
- 4.5.3. Хянан баталгааны тайлан, дүгнэлт;
- 4.5.4. Холбогдох бусад баримт материал.

#### **Тав. Мэдээллийн санд тавигдах шаардлага**

5.1. Газрын мониторингийн мэдээллийн сангийн өгөгдөл мэдээллийг бүрдүүлэхдээ энэ журам болон холбогдох бусад хууль, журам, заавар, арга зүйг дагаж мөрдөнө.

5.2. Газрын мониторингийн мэдээллийн санг цахим хэлбэрээр бүрдүүлэх бөгөөд газрын зураг, график, бичгийн хэлбэртэй байна.

5.3. Газрын мониторингийн мэдээллийн сангийн орон зайн өгөгдөл, мэдээллийг Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан байршил, өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд хийнэ.


5.4. Газрын мониторингийн систем нь газрын нэгдмэл сангийн нэгдсэн удирдлагын бусад системүүд, мэдээлэл нийлүүлэгчид болон хэрэглэгчидтэй мэдээлэл солилцохдоо сервис үйлчилгээгээр дамжуулна.

5.5. Хэрвээ энэхүү журмын 5.4-т заасан сервис үйлчилгээгээр мэдээлэл солилцох боломжгүй бол тоон хэлбэрээр зөөвөрлөх ба зөөвөрлөх хэлбэр, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлын талаар хамтран ажиллах гэрээнд тодорхой тусгасан байна.

5.6. Өгөгдөл мэдээлэл нь цаасан хэлбэртэй бол түүнийгээ тоон хэлбэрт шилжүүлж мэдээллийн санд оруулж болох бөгөөд уг асуудлыг агентлагийн даргын тушаалаар шийдвэрлэнэ.

5.7. Энэхүү журмын 4.5-т заасан цаасан баримт, материалуудыг ".pdf" өргөтгөлтэйгөөр 300 дрі-ын нягтралтайгаар тоон хэлбэрт хөрвүүлж мэдээллийн санд оруулна.

5.8. Мэдээллийн сангаас хэрэглэгчид дор дурдсан зорилгоор мэдээллийг ашиглана. Үүнд:



5.8.1. Төрийн захиргааны байгууллага нь хуульд заасан эрх, үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээллийг авч, албан ажлын хэрэгцээнд;

5.8.2. Аливаа байгалийн болон хүний үйл ажиллагаанаас үүсэх эрсдэлийг үнэлэхэд;

5.8.3. Аливаа газрын мониторингийн судалгаа шинжилгээний ажилд;

5.8.4. Шаардлагатай бусад үйл ажиллагаанд холбогдох журмын хүрээнд ашиглана.

**Зургаа. Үндсэн хэрэглэгч буюу мэдээлэл түгээгчийн чиг үүрэг**

6.1. Үндсэн хэрэглэгч буюу агентлаг дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

6.1.1. Газрын мониторингийн системийн үйл ажиллагааг улсын хэмжээнд нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах, эрхлэх;

6.1.2. Газрын мониторингийн мэдээллийн сангийн өгөгдэл, мэдээллийг бүрдүүлэх, баяжуулах, хадгалах, хамгаалах, ашиглах үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, баталгаажуулах;

6.1.3. Газрын мониторингийн системийн хүрээнд програм хангамж, техник технологи, хүний нөөцийн нэгдмэл бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэх;

6.1.4. Газрын мониторингийн системийн хүний нөөцийг /Төрийн болон төрийн бус байгууллага, газрын мэргэжлийн байгууллагын холбогдох албан хаагчид/ сургаж бэлтгэх, мэргэшүүлэх;

6.1.5. Мэдээллийн үнэн зөв байдал, мэдээллийн сангийн хэвийн ажиллагаа, хамгаалалт, хадгалалт, нөөцлөлт, хуулбарлалт, аюулгүй байдлыг хариуцах;

6.1.6. Газрын мониторингийн мэдээллийн сангийн нөөц хувь бүрдүүлэх ажлыг Үндэсний data төвтэй хамтран зохион байгуулах;

6.1.7. Мэдээлэл нийлүүлэгч байгууллагатай харилцан мэдээлэл солилцох гэрээ байгуулж ажиллах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих;


6.1.8. Мэдээлэл нийлүүлэгч байгууллагад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;

6.1.9. Газрын мониторингийн системийг хөгжүүлэх асуудлаар гадаадын болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах.

6.2. Мэдээлэл түгээгч буюу, аймаг, нийслэл, дүүргийн газрын алба, сумын газрын даамал дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

6.2.1. Газрын мониторингийн мэдээллийн сангийн мэдээллийг бусад иргэн, хуулийн этгээдээс цуглуулах, сонгох, няглан шалгах ажлыг зохион байгуулах;

6.2.2. Олон нийтийн хэрэгцээнд шаардлагатай мэдээлэл боловсруулах;



6.2.3. Газрын мониторингийн мэдээллийн санг бүрдүүлэх өгөгдөл, мэдээллийн бүртгэл хөтлөх, баримтжуулах;

6.2.4. Газрын мониторингийн мэдээллийн санд халдлага, гэмтэл гарсан даруйд холбогдох байгууллагад мэдэгдэх, түүний хэвийн үйл ажиллагааг сэргээх;

6.2.5. Газрын мониторингийн мэдээллийн сангийн өгөгдөл, мэдээллийн нэгдсэн тайланг жил бүр газрын мониторингийн системээс гаргаж, цахимар тайлагнах;

6.2.6. Хэрэглэгчийг газрын мониторингийн мэдээллийн сангаас өгөгдөл, мэдээлэл авах нөхцөл боломжоор хангах.

#### **Долоо. Мэдээлэл нийлүүлэгчийн чиг үүрэг**

7.1. Газрын мониторингийн мэдээллийн санд мэдээлэл нийлүүлэх үүрэг бүхий байгууллага дараах нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ:

7.1.1. Газрын мониторингийн мэдээллийн санд өгөгдөл, мэдээллийг хэрэглэгчийн эрхээр нэвтэрч сервис үйлчилгээгээр нийлүүлэх;

7.1.2. Нийлүүлэх өгөгдөл, мэдээллийн анхдагч боловсруулалтыг хийх;

7.1.3. Өгөгдөл, мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг хариуцах;

7.1.4. Шинээр бий болсон өгөгдөл, мэдээллийг тухай бүрт нь нийлүүлэх;

7.1.5. Өгөгдөл, мэдээллийн нэмэлт, өөрчлөлт, шинэчлэлтийг тухай бүрт нь хийх;

7.1.6. Агентлагтай байгуулсан хамтран ажиллах гэрээнд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

7.2. Газрын мониторингийн системийн үндсэн хэрэглэгчтэй мэдээлэл нийлүүлэх гэрээ байгуулсны үндсэн дээр мэдээлэл солилцено. Гэрээнд дараах нөхцөлийг заавал тусгана. Үүнд:

7.2.1. Нийлүүлэх өгөгдөл, мэдээллийн нэр, төрөл;

7.2.2. Өгөгдөл, мэдээлэл тогтмол нийлүүлэх хугацаа;

7.2.3. Өгөгдөл, мэдээлэлд өөрчлөлт, шинэчлэлт хийх талаарх мэдээлэл;

7.2.4. Өгөгдөл, мэдээлэл нь төлбөртэй эсэх, төлбөрийн хэмжээ;

7.2.5. Гэрээний талуудын эрх, үүрэг.

#### **Найм. Газрын мониторингийн мэдээллийн санд хандах хэрэглэгчийн эрх, үүрэг**

8.1. Энэхүү журмын 1-р хавсралтад заасан үндсэн хэрэглэгч болон тусгай эрхтэй хэрэглэгчийн жагсаалтад орсон албан хаагчдад агентлагийн даргын тушаалаар газрын мониторингийн системд нэвтрэх эрхийг олгох, өөрчлөх, хаах асуудлыг шийдвэрлэнэ.



8.2. Газрын мониторингийн системд хандах албан хаагчийн эрх, үүргийг энэхүү журмын 1-р хавсралтаар заасны дагуу олгоно.

8.3. Удирдлагын дэд системд хандах эрхийг системийн админ агентлагын даргын тушаалыг үндэслэн нээж, өөрчилж, хаана.

8.4. Удирдлагын дэд системд хандах эрх нээлгэх, өөрчлөх, хаалгах тохиолдолд дор дурдсан шаардлагыг хангасан байна. Үүнд:

8.4.1. Газрын мониторингийн системд хандах эрх нээлгэх, өөрчлөх, хаалгах хүсэлтийг агентлагт албан бичгээр ирүүлэх ба эрх нээлгэх албан хаагчийн холбогдох утасны дугаар, цахим шуудангийн хаяг, албан тушаалын тодорхойлолтын хамт хавсаргасан байх;

8.4.2. Газрын хянан баталгаа, мониторингийн ажлыг гүйцэтгэхээр шалгарсан хуулийн этгээд системд хандах эрх нээлгэх, сунгах, хүсэлт гаргах тохиолдолд тухайн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, мэргэжлийн байгууллагын эрхийн гэрчилгээ болон тухайн ажлыг гүйцэтгэхээр шалгарсан болохыг тодорхойлсон захиалагчийн албан бичиг, эрх олгосон шийдвэр, захиалагчтай байгуулсан гэрээний хуулбар, эрх олгох шийдвэрийг хавсаргасан байх;

8.4.3. Хуулийн этгээдийг бүрэн төлөөлж газрын мониторингийн системд хандах албан хаагчийн мэдээллийг энэ журмын 8.4.1-т заасны дагуу ирүүлэх;

8.4.4. Газрын мониторингийн системийн сургалтад хамрагдаж сертификат авсан байх.

8.5. Газрын мониторингийн системд нэвтрэх нэр, нууц үгийг тухайн албан хаагчийн цахим хаягаар системийн админ хүргүүлэх бөгөөд нууц үгийн нууцлалыг тухайн албан хаагч өөрөө хариуцна.

8.6. Газрын мониторингийн системд хандах албан тушаалтны нэвтрэх нэр, түүнд орсон өөрчлөлтийн талаарх бүртгэлийг системийн админ энэхүү журмын 2-р хавсралтын дагуу хөтөлнө.

8.7. Газрын мониторингийн системд хандах эрхийн хугацаа нь мэргэжлийн байгууллагад газрын төлөв байдал, чанар, нөхөн сэргээлт хийх мэргэжлийн байгууллагын эрхийн хугацаагаар тодорхойлогдоно.

8.8. Энэ журмын 8.1-т заасан системд нэвтрэх эрх бүхий албан тушаалтан өөр албан тушаалд томилогдсон, чөлөөлөгдсөн хугацаанаас хойш хуанлийн 7 хоногийн дотор тухайн аймаг, нийслэлийн газрын албанаас албан бичгээр агентлагт мэдэгдэж нэвтрэх эрхийг хүчингүй болгуулах тухай хүсэлт гаргана.

8.9. Газрын мониторингийн системд хандах эрх бүхий албан хаагч нь жирэмсний амралт, ээлжийн амралт, чөлөөтэй байх хугацаанд түүний албан үүргийг



түр орлон гүйцэтгэгчид газрын мониторингийн системд хандах эрхийг тухайн байгууллагын даргын тушаалыг үндэслэн системийн админ олгоно.

8.10. Газрын мониторгийн системийн хэрэглэгчийн дэд системд хандахдаа иргэд, аж ахуйн нэгж, байгууллага танилт нэвтрэлтийн “ДАН” системээр дамжин нэвтэрнэ.

#### **Ес. Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийх**

9.1. Газрын мониторингийн систем нь газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг цахим хэлбэрээр хийх нөхцөл, боломжийг хангасан байна.

9.2. Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны цахим үйл ажиллагаа нь дараах үе шатны ажлуудаас бүрдэнэ. Үүнд:

9.2.1. Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлыг эхлүүлэх, төсөл үүсгэх;

9.2.2. Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны бэлтгэл, хээрийн судалгаа, материал боловсруулалт, тайлан боловсруулалт зэрэг үе шатны ажлыг гүйцэтгэх;

9.2.3. Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны тайлан, дүгнэлтийг баталгаажуулах.

9.3. Аймаг, нийслэл, дүүргийн газрын албанаас газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчид газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгаа хийлгүүлэх мэдэгдэх хуудсыг газрын мониторингийн системээс хэвлэж өгнө.

9.4. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь өөрөө газрын мониторингийн системд танилт нэвтрэлтийн “ДАН” системээр дамжуулан нэвтэрч, мэдэгдэх хуудсыг хэвлэж авч болно.


9.5. Улс, орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр хийгдэх улсын хянан баталгааны ажлыг хийлгүүлэх мэдэгдэх хуудсыг агентлагын суурь судалгаа, мониторингийн хэлтсийн холбогдох албан тушаалтан хэвлэнэ.

9.6. Энэхүү журмын 9.3, 9.4, 9.5-т заасан мэдэгдэх хуудсыг мэргэжлийн байгууллагад өгч, мэргэжлийн байгууллага нь мэдэгдэх хуудасны дугаарыг газрын мониторингийн системд бүртгүүлснээр хянан баталгааны ажил эхэлнэ.

9.7. Мэдэгдэх хуудасны агуулга, загварыг энэхүү журмын 3-р хавсралтын дагуу бэлтгэж, хэвлэнэ.

9.8. Мэргэжлийн байгууллага нь хянан баталгааны ажлыг цахим байдлаар хийж гүйцэтгэнэ.

9.9. Мэргэжлийн байгууллага нь хянан баталгааны ажлыг гүйцэтгэх хугацаандаа мэдэгдэх хуудасны дугаараар дамжуулан газрын кадастрын



мэдээллийн сан, байгууллагын орон зайн мэдээллийн санд хандаж зөвхөн тухайн нэгж талбартай холбоотой мэдээллийг олж авна.

9.10. Хөрсний лаборатори нь хөрсний дээжийг шинжилж, шинжилгээний хариуг газрын мониторингийн системээр дамжуулан ерөнхий болон байнгын шинжээч, мэргэжлийн байгууллагад хүргүүлнэ.

9.11. Мэргэжлийн байгууллага нь хянан баталгааны сүлжээний зураглалыг газрын мониторингийн системд цахим хэлбэрээр гүйцэтгэж, мэдээллийн санд хадгална.

9.12. Мэргэжлийн байгууллага нь тайлан, дүгнэлтийг газрын мониторингийн системд боловсруулна.

9.13. Мэргэжлийн байгууллага шинжээчээр баталгаажуулах тайлан, дүгнэлтээ газрын мониторингийн системд тоон хэлбэрээр, хүсэлтийг албан бичгээр ерөнхий болон байнгын шинжээчид хүргүүлнэ.

9.14. Мэргэжлийн байгууллага тайлан, дүгнэлтийг баталгаажуулах этгээдийг сонгохдоо газрын кадастрын мэдээллийн санд автоматаар орон зайн шүүлт хийх эсхүл тусгайлан бэлтгэсэн асуулгын дагуу хариулж, холбогдох нотлох баримтыг үндэслэнэ.

9.15. Байнгын шинжээчээр баталгаажуулах тайлан, дүгнэлт бүхий газар нь дараах зориулалт, төрөл байна. Үүнд:

9.15.1. Гэр бүлийн зориулалттай газар;

9.15.2. Барилгын суурь нь нийт газрын 90 хувиас дээш талбайг эзэлж буй газар;

9.15.3. Газрын нийт талбайн 85 хувиас дээш талбай нь хатуу хучилттай газар;

9.15.4. Гэр бүлийн зориулалтаас бусад зориулалтын газарт эрх авснаас хойш 2 жил хүртэлх хугацаанд огт газар ашиглалт явагдаагүй газар.


9.16. Ерөнхий шинжээчээр баталгаажуулах тайлан, дүгнэлт бүхий газар нь дараах зориулалт, төрөл байна. Үүнд:

9.16.1. Энэхүү журмын 9.15.1-9.15.4-т зааснаас бусад газар;

9.16.2. Гэр бүлийн зориулалттай газарт хүний эрүүл мэнд, байгаль орчинд серөг нөлөөлөл үзүүлэхээр зориулалтын бус үйл ажиллагаа явагдаж буй газар.

9.17. Ерөнхий шинжээч нь байнгын шинжээчийн тайлан, дүгнэлт хянах, баталгаажуулах үйл ажиллагаанд хяналтыг газрын мониторингийн системээр дамжуулан тавина.

9.18. Ерөнхий шинжээч болон байнгын шинжээч нь мэргэжлийн байгууллагын үйлдсэн тайлан, дүгнэлтийг шаардлагын дагуу боловсруулаагүй, хангалтгүй гэж



үзвэл хянан баталгааны мэргэжлийн байгууллагад алдаа дутагдлыг арилгах, сайжруулах зөвлөмжийн хамт буцаана.

9.19. Хянан баталгааны дүгнэлтийг баталгаажуулахдаа газрын мониторингийн системээс хэвлэгдсэн дүгнэлтэд ерөнхий шинжээч эсхүл байнгын шинжээч гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулан мэргэжлийн байгууллагад албан бичгийн хамт цаасан хэлбэрээр хүргүүлнэ.

9.20. Баталгаажсан хянан баталгааны цаасан хэлбэр бүхий дүгнэлтийг тоон хэлбэрт энэхүү журмын 5.7 дахь заалтын дагуу хөрвүүлэн системд оруулж, архивлана.

#### **Арав. Мэдээллийн сангийн санхүүжилт, төлбөрийн нөхцөл**

10.1. Газрын мониторингийн системийн үйл ажиллагааг улсын төсөв болон бусад эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

10.2. Газрын мониторингийн мэдээллийн сангийн мэдээлэл нь төлбөртэй байж болно.

10.3. Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан төлбөртэй түгээх мэдээллийн төрөл, төлбөрийн хэмжээг баримтална.

10.4. Иргэн, хуулийн этгээдийн өөрийн хөрөнгөөр цуглуулж, бүрдүүлсэн нэн чухал, шаардлагатай өгөгдөл, мэдээллийг агентлагийн даргын шийдвэрийн дагуу гэрээ байгуулан худалдан авч, мэдээллийн санд ашиглаж болно. Төлбөрийн хэмжээг гэрээнд тодорхой заасан байна.

10.5. Иргэн, хуулийн этгээд нь улсын төсөв, шинжлэх ухаан, технологийн сан, олон улсын болон гадаадын зээл, тусlamж, төсөл хөтөлбөрийн хүрээнд бүрдүүлсэн газрын төлөв байдал чанарын хянан баталгааны мэдээллийг мониторингийн мэдээллийн санд үнэ төлбөргүй төвлөрүүлэх үүрэгтэй.

10.6. Газрын мониторингийн системийн сургалт зохион байгуулах үйл ажиллагаанаас олсон орлогыг сургалтын үйл ажиллагаа, газрын мониторингийн системийн хөгжүүлэлтэд зарцуулна.

10.7. Хянан баталгааны ажлын тайланг хянах, дүгнэлтийг баталгаажуулах Засгийн газрын эрх бүхий байгууллагаас баталсан тарифийн дагуу хураамж авч, хянан баталгаа, мониторингийн үйл ажиллагаанд хяналт тавихад зарцуулна.

10.8. Энэ зүйлд заасан төлбөртэй мэдээллийн орлогын 50 хүртэлх хувийг газрын мониторингийн мэдээллийн санг шинэчлэх, үйлчилгээний хүрээг нэмэгдүүлэх, түүний хүчин чадлыг сайжруулахад зарцуулна.

#### **Арван нэг. Мэдээллийг хадгалах, хамгаалах, тайлagonах**



11.1. Улсын хэмжээний газрын мониторингийн мэдээллийн санг агентлагийн архивд нөөц хувь хадгалах ажлыг тус байгууллагын мэдээллийн технологийн асуудал хариуцсан нэгжийн инженер удирдаж, суурь судалгаа, мониторингийн асуудал хариуцсан нэгжийн Газрын мониторингийн системийн асуудал хариуцсан мэргэжилтэн, архивын нэгжийн мэргэжилтэн настай хамтран жил бүрийн 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор зохион байгуулна.

11.2. Аймаг, нийслэл, дүүргийн Газрын албаны архивд шууд бус өгөгдөл бүхий цаасан баримтыг газрын мониторингийн асуудал хариуцсан мэргэжилтэн, архивын эрхлэгч нар хамтран архивлах ажлыг зохион байгуулна.

11.3. Газрын мониторингийн мэдээллийн сангийн өгөгдөл, мэдээлэл нь техникийн гэмтэл, программ хангамжийн алдаа болон бусад шалтгааны улмаас устсан тохиолдолд агентлагийн даргын тушаалаар ажлын хэсэг байгуулж, устсан шалтгааныг тогтоон албан ёсны тэмдэглэл үйлдэнэ.

11.4. Энэхүү журмын 11.3-т дурдсан тохиолдол гарвал шалтгааныг тогтоосон тэмдэглэлийг үндэслэн нөөц серверт хадгалсан мэдээллийн санг агентлагийн даргын зөвшөөрлөөр ажлын хэсэг сэргээнэ.

11.5. Газрын мониторингийн мэдээллийн санд өөрчлөлт орж байгаа болон шинээр нэмэгдэж байгаа мэдээллийн үнэн зөв байдал, бусад баримт бичгийн бүрдүүлэлтэд тавих хяналтыг агентлаг хагас жил тутам хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд түүвэрлэн шалгالت хийж болно.

11.6. Агентлагийн газрын мониторингийн тайланг жил бүр гаргаж, газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад дараа оны 02 дугаар сарын 15-ны дотор тайлагнана /Тухайн оны Газрын нэгдмэл сангийн тайлангийн хамт/.

#### **Арван хоёр. Мэдээллийн сангаас лавлагаа өгөх**


12.1. Иргэн, хуулийн этгээдээс зөвхөн албан бичгээр хүсэлт ирүүлсэн тохиолдолд лавлагаагаар үйлчилнэ.

12.2. Иргэн, хуулийн этгээдэд цаасан болон тоон хэлбэрийн мэдээллээр үйлчилнэ.

12.3. Энэхүү журмын 12.2-т заасан үйлчилгээг 10.3-т заасан төлбөрийн хэмжээний дагуу төлбөртэйгөөр үйлчилж болно.

#### **Арван гурав. Хяналт, шалгалаа болон хэвийн үйл ажиллагаа**

13.1. Агентлаг нь улсын хэмжээнд мэдээллийн санд хяналт, шалгалаа хийнэ.



13.2. Газрын мониторингийн системийн үйл ажиллагаанд агентлагийн суурь судалгаа, мониторингийн асуудал хариуцсан нэгж нь хяналт шалгалт хийх ажлыг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулна.

13.3. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг холбогдох хууль, журмын дагуу агентлагийн даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар оруулан танилцуулж, шийдвэр гаргуулан зөрчлийг бүрэн арилгуулах арга хэмжээг авч ажиллана.

13.4. Мэдээллийн санд хяналт, шалгалт хийсэн материалыг агентлагийн суурь судалгаа мониторингийн асуудал хариуцсан нэгж нь архивлаж хадгална.

13.5. Мониторингийн сүлжээний программ хангамж, сервер, сүлжээний аюулгүй байдал, хэвийн үйл ажиллагаанд мэдээлэл, технологийн асуудал хариуцсан нэгж хяналт тавих ба газрын мониторингийн системийн аюулгүй байдал болон хэвийн тасралтгүй үйл ажиллагааг улсын хэмжээнд бүрэн хариуцаж ажиллана.

#### **Арван дөрөв. Хориглох зүйл**

14.1. Газрын мониторингийн систем, программ хангамж, түүнтэй холбоотой нууцын зэрэглэлд хамарагдах мэдээ, файлын бүтэц, газрын төлөв байдлын чанарын талаарх аливаа мэдээллийг бусдад хувилан тараах, дамжуулах, санаатай болон санамсаргүй задруулахыг хориглоно.

14.2. Газрын мониторингийн мэдээллийн санд хандах эрх бүхий албан хаагчаас бусад этгээд уг системд хандахыг хориглоно.

14.3. Энэхүү журамд заасан болон хамтран ажиллах гэрээ байгуулсан мэдээлэл нийлүүлэгчээс бусад аливаа этгээдээс мэдээлэл авч мэдээллийн санд оруулахыг хориглоно.

#### **Арван тав. Хүлээлгэх хариуцлага**

15.1. Мэдээллийн санд хандах албан хаагчийн нэвтрэх нэр, нууц үгийг тухайн этгээд болон системийн админ хадгалах бөгөөд алдсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

15.2. Энэхүү журмыг зөрчин мэдээллийг зөвшөөрөлгүй хувилан тараасан, бусдад шилжүүлсэн, мэдээллийн санг хуулах, устгах, өөрчлөлт хийхийг оролдсон буюу ажлын хариуцлага алдсан албан хаагчид зөрчлийн шинж учруулсан хохирлыг харгалзан зохих хууль журамд заасны дагуу арга хэмжээ авахаас гадна шаардлагатай тохиолдолд хуулийн байгууллагаар шийдвэрлүүлнэ.

15.3. Иргэд, олон нийтэд үйлчилсэн лавлагаа, мэдээллийн үнэн зөв эсэхийг тухайн аймаг, нийслэл, дүүргийн Газрын албаны холбогдох мэргэжилтнүүд, сумын Газрын даамал хариуцна.




15.4. Хөрсний шинжилгээний үзүүлэлтийг буруу тодорхойлсон бол тухайн хөрсийг шинжилсэн хөрсний итгэмжлэгдсэн лабораториид хариуцлага хүлээлгэхээр холбогдох эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ.

15.5. Мэдээллийн буруу эсэх талаарх гомдлыг иргэн, хуулийн этгээд нь тухайн албан хаагчийн дээд шатны албан тушаалтанд гаргах бөгөөд гаргасан шийдвэрийг эс зөвшөөрсөн тохиолдолд маргааныг шүүхээр шийдвэрлүүлнэ.

15.6. Мэргэжлийн байгууллага хянан баталгааны тайлан, дүгнэлтийг боловсруулахдаа мэргэжлийн ёс зүй, холбогдох хууль, тогтоомжийг мөрдөөгүй, хөрсний шинжилгээний үзүүлэлт, баталгаажсан баримт бичгийг хуурамчаар үйлдвэл мэргэжлийн эрх олгосон эрх бүхий этгээдэд хандаж, хянан баталгааны мэргэжлийн байгууллагын эрхийг цуцлах хүртэлх арга хэмжээг авахаар шийдвэрлүүлнэ.

--- o0o ---



“Газрын мониторингийн системийг ажиллуулах журам”-ын нэгдүгээр хавсралт

“Газрын мониторингийн системийг ажиллуулах  
журам”-ын хоёрдугаар хавсралт

Газрын мониторингийн системд хандах хэрэглэгчийн эрх нээх,  
өөрчлөх, хаахад бүртгэх бүртгэлийн загвар

№	Аймаг /нийслэл/, сум /дүүрэг/-ын нэр	Албан тушаал	Албан тушаалтны нэр	Нэвтрэх нэр	Огноо	Эрх нээсэн, өөрчилсөн, хаасан эсэх	Эрх бүхий албан тушаалтны шийдвэр	Шийдвэрийн огноо
1.								
2.								
3.								
...								
...								

Бүртгэл хөтөлсөн: ..... / ..... /



“Газрын мониторингийн системийг ажиллуулах  
журам”-ын гуравдугаар хавсралт

**ГАЗРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧАНАРЫН ХЯНАН  
БАТАЛГААНЫ АЖИЛ ХИЙЛГЭХ МЭДЭГДЭХ ХУУДАСНЫ  
ЗАГВАР, ТОДОРХОЙЛОЛТ**

1. Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлын мэдэгдэх хуудас /цаашид мэдэгдэх хуудас/-ны загварыг тодорхойлов.
2. Мэдэгдэх хуудас нь Газрын тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.5 дахь заалтыг тусгасан байна.
3. Мэдэгдэх хуудасны загварыг тодорхойлолтод тусгав.

**МЭДЭГДЭХ ХУУДАСНЫ НҮҮРЭН ТАЛ, АГУУЛГА**

1. Мэдэгдэх хуудас нь А4 форматтай байна.
2. Мэдэгдэх хуудасны зүүн доод буланд нэгж талбарын тойм зураг 80x55 мм-ийн хэмжээтэй байрлах ба баруун доод буланд мэдэгдэх хуудасны давтагдахгүй дугаарлалтыг агуулсан QR-код 30x30 мм-ийн хэмжээтэй байрлана.
3. Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажил хийлгэх мэдэгдэх хуудасны дугаарыг 16 оронтой /\*\*\*\*-\*-\*-\*\*\*\*-\*\*-\*\*\*\*/ тоогоор тэмдэглэж, ангилал кодыг оруулна.
  - A. /\*\*\*\*/ - аймаг, дүүргийн зипкодны орон;
  - B. /\*/ - Хянан баталгаа хийлгэх үндэслэл /Эзэмших, ашиглах эрхийн хугацаа сунгах, эрх шилжүүлэх, хянан баталгааны хугацаа дуусах/;
  - C. /\*/ - Газар ашиглах эрхийн төрөл /өмчлөх, эзэмших, ашиглах/;
  - D. /\*\*\*\*/ - Газрын зориулалт;
  - E. /\*/ - он;
  - F. /\*\*\*\*/ - Хянан баталгааны ажлын дугаарлалт.

